



НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

Үүрэг хэрэгжүүлэх тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалт, Улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2015 оны 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1.Албаны хэмжээний “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн систем”-д өдөр тутам биечлэн хяналт тавьж ажиллахыг дэд дарга, /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, дүүргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч/ нарт үүрэг болгосугай.

2.Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журмын дагуу нөхөн төлбөр олгуулах, буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, төлбөр авагчид буцаасан гүйцэтгэх баримт бичиг сэргээх, харьяаллын дагуу шилжүүлэх гүйцэтгэх баримт бичигт хяналт тавьж ажиллахыг дэд дарга, /хошууч Ж.Нандинтуул, дүүргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч/ нарт үүрэг болгосугай.

3.Албаны дотоодын хяналт шалгалтыг сайжруулж, гүйцэтгэх баримт бичигт иж бүрэн, хэсэгчилсэн, гэнэтийн шалгалтыг явуулж, тооллого хийх ажлыг зохион байгуулж ажиллахыг мэргэжилтэн, /хошууч Э.Дүүрэнцэнгэл, ахмад Ч.Мөнхсайхан/ нарт үүрэг болгосугай.

3.Төлбөрийн дансанд төвлөрсөн мөнгөн хөрөнгийг хуульд заасан хугацаанд төлбөр авагчид олгоход шийдвэр гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлж, төлбөр авагчийн хаяг тодорхойгүйгээс хуримтлагдсан мөнгөн хөрөнгийг нийтэд зарлах ажлыг хуульд зааснаар зохион байгуулж ажиллахыг ахлах нягтлан бодогч /хошууч Ш.Саранчимэг/, бүртгэл хариуцсан ажилтан /ахлах дэслэгч Б.Баасанханд/ нарт үүрэг болгосугай.

4.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан албанаас шүүхэд хариуцагчаар оролцсон гүйцэтгэх баримт бичгийн талаар бүс хариуцсан ахлах мэргэжилтэнд танилцуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүрт авч, шүүхэд албыг төлөөлөх ажлыг хуулийн хугацаанд шуурхай зохион байгуулахыг мэргэжилтэн /ахмад Б.Содгэрэл/-д үүрэг болгосугай.

112015000007

2014 tushaal

5.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад гарч болзошгүй гэмт халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг ханган ажиллах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг эрэн сурвалжлах хэсгийн дарга, /хошууч Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

6.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж ял завшихаас урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг ахлах шийдвэр гүйцэтгэгч /дэслэгч Р.Цэнд-Аюуш/-д үүрэг болгосугай.

7.Тушаалын дагуу 2015 оны 02 дугаар сарын 02-ны дотор төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг дэд дарга, /дэд дарга, дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул, хэсгийн дарга, хошууч Н.Батсүх, мэргэжилтэн, хошууч Э.Дүүрэнцэнгэл, ахмад Ч.Мөнхсайхан, ахлах нягтлан бодогч, хошууч Ш.Саранчимэг, ахлах шийдвэр гүйцэтгэгч дэслэгч Р.Цэнд-Аюуш/ нарт даалгасугай.

8.Тушаалын биелэлтийг сар бүрийн 25-ны дотор албаны даргад илтгэх хуудсаар танилцуулахыг дэд дарга, /дэд хурандаа Ч.Оюунцэцэг, хошууч Ж.Нандинтуул, хэсгийн дарга, хошууч Н.Батсүх, мэргэжилтэн, хошууч Э.Дүүрэнцэнгэл, ахмад Ч.Мөнхсайхан, ахлах нягтлан бодогч, хошууч Ш.Саранчимэг, ахлах шийдвэр гүйцэтгэгч дэслэгч Р.Цэнд-Аюуш / нарт, улирал бүр Шийдвэр гүйцэтгэх газарт нэгтгэн хүргүүлэхийг хүний нөөц, сургалт мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, /дэслэгч П.Сумъяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА



Э.БАТБАЯР